



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 01 сарын 24 өдөр

Дугаар A/05

Даланзадгад

Г Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед  
ажиллах баг томилох тухай

Эрүүл мэндийн Сайдын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/438, 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/11 тоот тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ажиллах багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, томилсугай.
2. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ажиллах багийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн чанарын албаны дарга наарт үүрэг болгосугай.
3. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ажиллах багийг холбогдох мэдээллээр хангаж, хамtran ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн төвүүдийн дарга, эрхлэгч наарт, багийн зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлийн дагуу хариуцлагатай ажиллахыг багийн дарга нар, гишүүдэд даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга наарт тус тус даалгасугай.

ДАРГА

Ц.ӨНӨРЖАРГАЛ



Эрүүл мэндийн газрын даргын  
2019 оны 01 сарын 24 өдрийн А/Б тоот  
тушаалын нэгдүгээр хавсралт



ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД АЖИЛЛАХ  
БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

**1. Санхүү, төлөвлөлтийг зохицуулах баг:**

Ахлагч: Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга  
Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд: Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал  
Эрүүл мэндийн газрын эдийн засагч  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн санхүү эдийн засгийн албаны дарга  
Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн мэргэжилтэн  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүний нөөцийн албаны дарга  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эм зүйч  
Эрүүл мэндийн газрын эмийн хангарт хариуцсан ажилтан  
Эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн

**2. Шуурхай хариу арга хэмжээний баг:**

Ахлагч: Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга  
Нарийн бичгийн дарга: Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Гишүүд: Нийгмийн эрүүл мэндийн төвийн халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн  
Эрүүл мэндийн газрын халдварт судлаач  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тархвар судлаач  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эрүүл ахуйч  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дүн бүртгэгч

**3. Эмнэлзүйн баг:**

Ахлагч: Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал  
Нарийн бичиг: Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Гишүүд: Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтсийн дарга  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Чанарын албаны дарга  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэлтийн зөвлөх эмч  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүүхдийн зөвлөх эмч  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дурс оношилгооны зөвлөх эмч  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдвартын зөвлөх эмч  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дотрын эмч  
Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтсийн сувилахуйн мэргэжилтэн  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сувилахуйн албаны дарга  
Өрхийн эрүүл мэндийн төвийн ахлагч нар

**4. Эрсдэл харилцаа холбооны баг:**

Ахлагч: Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга  
Нарийн бичиг: Эрүүл мэндийн газрын мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Эрүүл мэндийн газрын халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн  
Эрүүл мэндийн газрын мэдээлэл технологийн мэргэжилтэн  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэдээлэл технологийн ажилтан  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан

Эрүүл мэндийн газрын даргын  
2019 оны 01 сарын 24. едрийн 05 тоот  
тушаалын хоёрдугаар хавсралт

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД АЖИЛЛАХ БАГИЙН  
ЧИГ ҮҮРЭГ

**1. Санхүү, төлөвлөлтийг зохицуулах баг:**

- 1.1 Хариу арга хэмжээний ерөнхий удирдлагыг ханган, багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулна
- 1.2 Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангуулж ажиллана
- 1.3 Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед шаардагдах орны тооцоолол, судалгаа гаргаж, дэгдэлтийн үед орны зохион байгуулалт хийх, ор дэлгэх нэмэлт төлөвлөгөөг жил бүр гарган, төсөвт тусгах
- 1.4 Улирлын томуугийн эсрэг вакцин, эм бэлдмэлийн тооцоог улирал угтуулан гаргаж, нөөцийг хангана
- 1.5 Томуу, томуу төст өвчний улирлын үед шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдвартгүйтгэл, эмч ажилчдыг халдвараас хамгаалах хувцас хэрэглэл, дархлаа дэмжих бүтээгдэхүүн, авто машин, тоног төхөөрөмж, хүний нөөцийн тооцоо судалгааг гаргаж, нөөцийн төлөвлөгөө гаргах, нөөцийг хангуулах арга хэмжээ авах
- 1.6 Шаардлагатай үед уртасгасан цагаар нэмэлтээр ажиллуулна
- 1.7 Холбогдох арга хэмжээний төсөв тооцоог гарган, шийдвэрлүүлнэ

**2. Шуурхай хариу арга хэмжээний баг:**

- 2.1 Нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, мэргэжил арга зүй, удирдлагаар хангана
- 2.2 Салбар хоорондын байгууллагууд /ОБГ, ЦГ, бусад хүчинь байгууллагууд, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд/-тай хамтран ажиллана
- 2.3 Өвчлөлийн байдалтай уялдуулан мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг боловсруулан, эмч, эмнэлгийн ажилчид, ард иргэдэд хүргэнэ
- 2.4 Эрүүл мэндийн байгууллагуудаас доорх мэдээллүүдийг авч нэгтгэн, ЭМЯ руу цаг хугацаанд нь явуулна
- 2.5 Орны ачаалал батлагдсан, нэмэлт, дэлгэсэн, эрчимт эмчилгээний орны тоог хүүхэд, насанд хүрэгчдээр
- 2.6 Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа нийт өвчтөний тоо, үүнээс амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтөний тоо, насны бүлгээр
- 2.7 Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа нийт жирэмсэн эмэгтэйн тоо үүнээс амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтөний тоо, насны бүлгээр
- 2.8 Эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа өвчтөний тоо, насны бүлэг, Олон улсын өвчний 10 дугаар ангиллаар
- 2.9 Яаралтай тусlamжийн тасгийн үзлэгийн тоо, үүнээс томуу, томуу төст өвчний үзлэгийн тоо, насны бүлгээр
- 2.10 Түргэн тусlamжийн дуудлагын тоо, үүнээс томуу томуу төст өвчний шалтгаант дуудлагын тоо, насны бүлгээр

2.11 Нас баралтын тоо, үүнээс амьсгалын замын хүнд халдвартай шалтгаантай нас баралтын тоо, олон улсын өвчний 10 дугаар ангиллаар, насны бүлгээр

**3. Эмнэлзүйн баг:**

3.1 Амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтөний оношилгоо, эмчилгээнд телемидицинээр зөвлөгөө өгөх, хүнд өвчтөнийг эмнэлэг хооронд тээвэрлэх асуудлыг зохицуулна

3.2 Томуу, томуу төст өвчний үеийн тусlamж үйлчилгээний зохион байгуулалтыг шийдвэрлэх

3.3 Томуу, томуу төст өвчний эмнэлзүйн удирдамж, амьсгалын замын цочмог халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлэх эмнэлгийн тусlamж үйлчилгээний зөвлөмж өгөх

3.4 Өвчтөнийг эрэмбэлэн ангилах, жирэмсний үзлэг, хяналт, бага насны хүүхдийн товлолын дархлаажуулалт зэрэг амбулаториор үзүүлэх тусlamж үйлчилгээг өөр хэсэгт шилжүүлэх зэрэг нягтралыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ

3.5 Халдвараас сэргийлэлт хяналтын багийн тандалт, хяналтын үйл ажиллагааг идэвхжүүлэн, эмч, эмнэлгийн ажилтнуудад халдвараас сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж, хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр хангана

3.6 Амьсгал удирдах, ТТӨ-ний эмнэлзүйн удирдамжаар сургалт зохион байгуулна

**4. Эрсдэл харилцаа холбооны баг:**

4.1 Нөхцөл байдлын мэдээллийг олон нийтэд тухай бүрд шуурхай өгнө

4.2 Цаг үеийн байдлаар хэвлэлийн бага хурал зохион байгуулна

4.3 Олон нийтэд зориулсан мэдээ, мэдээлэл, зөвлөмж боловсруулан түгээнэ

4.4 Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулна

4.5 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний мэдээлэлд тандалт хийж, холбогдох арга хэмжээг шуурхай авна